

БАТЛАВ
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Р.МӨНХТОГТОХ



Сайнцагаан сум

2023 оны 9 дугаар сарын 19

МЭДЭГДЭЛ

Дундговь аймгийн Луус сумын Засаг дарга Б.Өлийхишиг, Жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн С.Отгонсүрэн, нягтлан бодогч Сумьяажаргал нарт

Сонсох ажиллагаа явуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Луус сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийлээ.

Аудитаар Луус сумын төсөл хэрэгжүүлэгч М.Оюундарь үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлснээс Хоршоо хөгжүүлэх санд 2,914,500.00 төгрөгийн хохирол учруулсан зөрчилд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 тоот тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8 -д заасны дагуу төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ. Үүнд:

Төлбөрийн акт :

1. Аудитаар Луус сумын төсөл хэрэгжүүлэгч М.Оюундарь үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн – **2,914,500.00 төгрөг**

Иймд Захиргааны Ерөнхий хуульд заасны дагуу 2023 оны 9 дугаар сарын 19-ны өдрийн 12.00 цагт сонсох ажиллагааг биечлэн явуулах болсныг үүгээр мэдэгдэж байна.

Сонсох ажиллагаа нь дараах дарааллаар явагдана. Үүнд:

1. Захиргааны шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэлийг танилцуулах;
2. Захиргааны шийдвэр гаргах асуудлын талаарх үндэслэл, шалтгаан нөхцөлийг танилцуулах;
3. Санал сонсох.

Мэдэгдлийг гардуулж өгсөн:

Ахлах аудитор _____ / Д.Ихбаяр /
албан тушаал гарын үсэг

Мэдэгдлийг хүлээн авсан:

Засаг дарга ----- / Б.Өлзийхишиг /

Жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн -----/С.Отгонсүрэн /

Нягтлан бодогч ----- / Сумьяажаргал /

албан тушаал

гарын үсэг

Мэдэгдлийг гардуулж өгсөн огноо: _____

**СОНСОХ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ТУХАЙ
ТЭМДЭГЛЭЛ**

№ _____

2023 оны 9-р сарын 19-ны өдөр

Сайнцагаан сум

Захиргааны ерөнхий хуулийн дагуу Дундговь аймгийн Луус сумын Засаг дарга Б.Өлийхишиг, Жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн С.Отгонсүрэн, нягтлан бодогч Сумьяажаргал нартай биечлэн уулзаж 2023 оны 9 дүгээр сарын 19-ны өдрийн 12.00 цагт сонсох ажиллагааг явууллаа.

Сонсох ажиллагаанд байгууллагыг төлөөлж:

Албан тушаал, нэр; Засаг дарга Б.Өлзийхишиг

Албан тушаал, нэр; Жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн С.Отгонсүрэн

Сонсох ажиллагааны бүрэлдэхүүнээс татгалзал бий эсэх: **Үгүй**

Татгалзаж байгаа шалтгаан: _____ гарын үсэг _____

Бүрэлдэхүүнийг зөвшөөрч байна. Гарын үсэг _____

Сонсох ажиллагаа явуулах болсон шалтгаан: Мэдэгдэлд дурдагдсан захиргааны шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэл, Захиргааны шийдвэр гаргах тухайн асуудлын талаарх шалтгаан нөхцөл, үндэслэл, мэдээллийг Дундговь аймгийн Луус сумын Засаг дарга Б.Өлийхишиг, Жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн С.Отгонсүрэн, нягтлан бодогч Сумьяажаргал нартай биечлэн уулзаж танилцуулав.

Асуулт: Ахлах аудитор Д.Ихбаяр.

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Луус сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийлээ.

Луус сумын төсөл хэрэгжүүлэгч М.Оюундарь үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлснээс Хоршоо хөгжүүлэх санд 2,914,500.00 төгрөгийн хохирол учруулсан зөрчилд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 тоот тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8 -д заасны дагуу төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ. Үүнд:

Төлбөрийн акт :

1. Аудитаар Луус сумын төсөл хэрэгжүүлэгч М.Оюундарь үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн – **2,914,500.00 төгрөг**

Д.Ихбаяр : Төсөл хэрэгжүүлэгчтэй холбоотой дээрх төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлгүй гэж үзвэл хариу тайлбар ирүүлж болно.

Хариулт: Засаг дарга Б.Өлзийхишиг, Жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн
С.Отгонсүрэн

1. Одоогоор хөршөө хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдэлтэй 3 зээлдэгч байна зээл авсан зээлдэгч нар зээлээ зориулалтын дагуу зарцуулж үйл ажиллагаагаа явуулж байна. Оёдлын чиглэлээр төсөл хэрэгжүүлж байгаа М.Оюундарь үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн, би өчигдөр мэдэгдэл хүргүүлэхдээ очиж уулзсан ойрын хугацаанд төлж барагдуулна гэсэн тайлбарыг өгсөн. Хугацааны хувьд 10 сарын 01-ны дотор төлүүлэх арга хэмжээ авч нотлох баримтыг албан тоотоор хүргүүлнэ.

Сонсох ажиллагааг 2023 оны 09 дугаар сарын 19-ны өдрийн 12.35 цагт дуусгав.

Сонсох ажиллагаанд оролцсон:

Захиргааны төлөөлөл: _____ / Д.Ихбаяр /

Оролцогч: _____ / Б.Өлзийхишиг /

_____ / С.Отгонсүрэн /

ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛГЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Луус сумын Хоршоо хөгжүүлэх сан
Тайланг хугацаа: 2023.09.01

№	Ажил гүйцэтгэний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шагалагч байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн харчуу, тайлбар	Гаргасан шийдэл	Шагалагч байгууллагын холбогдох хүний	
								Албан тушаал	Овог нэр
A	I	3	4	5	6	7	8	9	10
1	Зарлал	Луус сумын төсөл хэрэгжүүлэгч М.Оюундарь үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлснээс Хоршоо хөгжүүлэх санд нийт 2,914,500.00 төгрөгийн хохирол учруулсан зөрчил илэрлээ.	2,914,500	Төлбөрийн акт тогтоох	Засаг дарга Б.Өлзийхишиг, Нягтлан бодогч Э.Сумъяажаргал нарт 2023 оны 09 дүгээр сарын 19-ны танилцуулж сонсох ажиллагаа явуулсан. Аудиторын саналыг хүтээн зөвшөөрсөн	Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг төсөл хэрэгжүүлэгчээр төлүүлэх (2023 оны 9 дүгээр сарын 25)	Төлбөрийн акт тогтоох /	Засаг дарга, Нягтлан бодогч	Б.Өлзийхишиг, Э.Сумъяажаргал
Нийт дүн			2,914,500.00						

АХЛАХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ДИХБАЯР
ХНАРАНЦАЦРАЛ
Р.МӨНХТОГТОХ

ЗАСАГ ДАРГА
НЯГТЛАН БОДОГЧ



Б.ӨЛЗИЙХИШИГ
Э.СУМБЯАЖАРГАЛ



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон. 206, 207, 210, 213 тоот

7-р баг. Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090

Утас: 70592439, 70592208, 70593208

И-мэйл: dundgovi@audit.gov.mn

2023. 09.26

№

02/157

танай _____ -ны № _____ -т

**ЛУУС СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.ӨЛЗИЙХИШИГ ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Луус сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийлээ.

Аудитын явцад илэрсэн зээлийн хугацаа хэтрэлттэй холбоотой зөрчилд тогтоосон төлбөрийн актыг хүргүүлж байна.

Төлбөрийн актыг барагдуулж заасан хугацаанд хариу ирүүлэхийг хүсье.

Хавсралт.....² хуудас

ДАРГА

Р.МӨНХТОГТОХ

0012032635


**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 90

А/126 0315

Мандалговь

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Луус сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2023 оны 3дугаар улирлын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитаар Луус сумын төсөл хэрэгжүүлэгч М.Оюундарь үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлснээс Хоршоо хөгжүүлэх санд 2,914,500.00 төгрөгийн хохирол учруулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т */батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, Иргэний хуулийн 222.4-т /Хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгэгч нь түүнд ямар нэг тохиолдол нөлөөлсөн эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг хариуцна.../, 222.5-д /Монгол төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй/, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дугаар тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.11-д /Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ/, Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох, зээлдэгчтэй байгуулсан гэрээг тус тус зөрчсөн байна.*

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т */Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зорчсон бол төлбөрийн акт тогтооно/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:***

1. Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн 2,914,500.00 /Хоёр сая есөн зуун арван дөрвөн мянга таван зуун/ төгрөгийн зээл, хүүгийн авлагыг зээлдэгч иргэн /М.Оюундарь/ -аар Луус сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 100081055406 тоот дансанд 2023 оны 10 дүгээр сарын 05-ны дотор нөхөн төлүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹ т ирүүлэхийг Дундговь аймгийн Луус сумын Засаг дарга

¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593208

0012059446

Б.Өлзийхишиг, Нягтлан бодогч Э.Сумьяажаргал, Жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн С.Отгонсүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АХЛАХ АУДИТОР

Д.ИХБАЯР

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ